

**“Усны үндэсний хөтөлбөр”-ийн
ХХААХҮ-ийн салбарт хамаарах заалтын 2007 оны үйл ажиллагааны
хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүн**

2008 оны 11 сарын 03

НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

“Усны үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 2007 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудын гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгч цаашид зохион байгуулах ажлын үр дүн сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Хяналт шинжилгээ үнэлгээ хийхдээ Засгийн Газрын 2006 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 51 дугаар тогтоолоор баталсан “Яам, аймаг, нийслэлийн засаг даргын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ыг арга зүйн үндэс болгов.

Хяналт шинжилгээ үнэлгээг хийхдээ дараах аргуудыг хэрэглэн мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийсэн болно.

- **Баримт материалд дүн шинжилгээ хийх.** Хөтөлбөрийн хүрээнд 2007 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, 2007 оны төлөвлөгөөний гүйцэтгэл, худаг, услалтын систем, тэдгээрийн үр нөлөөг тооцоолоход шаардлагатай статистик үзүүлэлтүүд /2003 оноос хойших/, 2006 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, Бэлчээр, тариалангийн усжуулалтын чиглэлээр орон нутагт томилолтоор ажилласан удирдлага, мэргэжилтнүүдийн илтгэх хуудас, тайлан, Усны тухай хууль, Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны арга хэмжээний төлөвлөгөө зэрэг эх сурвалжуудыг судалсан.
- **Газар дээр нь очиж танилцах.** Шинээр барьсан, сэргээн засварласан худаг, услалтын системүүдийн ажлын гүйцэтгэл болон ашиглалтын байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилгоор Орхон, Булган, Архангай, Сэлэнгэ, Хөвсгөл, Дорнод, Хэнтий аймгуудад нийт 67 хүн/хоног томилолтоор ажилласан.
- **Ярилцлага, хэлэлцүүлэг хийх.** Томилолтоор ажиллах хугацаандаа малчид, тариаланчид /300 гаруй/, сум, аймгийн удирдлага, мэргэжилтнүүд /63/ -тэй уулзаж ярилцлага хийсний зэрэгцээ Булган, Хөвсгөл аймагт худгийн ажил гүйцэтгэж буй аж ахуйн нэгжүүдийн төлөөлөгч 13 хүнтэй уулзаж хэлэлцүүлэг хийсэн болно.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Усны үндэсний хөтөлбөр Монгол улсын засгийн газрын 1999 оны 143 дугаар тогтоолоор батлагдан 3 үе шаттай хэрэгжиж байна.

I үе шат	1999-2000 он
II үе шат	2001-2005 он
III үе шат	2006-2010 он

3.1. Хөтөлбөрийн зорилго

Хэрэглэгчдийг чанартай, хүрэлцээтэй усаар найдвартай хангах, усны нөөцийг нөхөн сэргээх, хомсдох, бохирдохоос хамгаалах замаар нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх

3.2. Хөтөлбөрийн зорилт

1. Усны нөөцийн хэмжээ, чанарыг тогтоох эрэл хайгуул, судалгаа, шинжилгээний ажлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулах, ус хэрэглээний өсөн нэмэгдэх хэрэгцээг тасралтгүй бүрэн хангах
2. Ус ашиглалтын уламжлалт арга, дэвшилтэт технологи, шинэлэг санаачилгыг нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагатай холбон судалж туршин нэвтрүүлэх
3. Ус ашиглалтын болон байгалийн бусад сөрөг нөлөөллөөс усны нөөц хомсдож, бохирдохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, байгалийн аясаар нөхөн сэргээгдэх чадавхийг дэмжих үйл ажиллагааг усны нөөц, чанарын мэдээллийг үндэслэн хэрэгжүүлэх замаар байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалах
4. Үерийн аюул, гамшиг болон гол мөрөн, булаг шандны ус татарч, улмаар хатаж ширгэх, усны эх үүсвэр блхирдох зэрэг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, учирсан хөнөөлийг арилгах, замаар иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх
5. Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагааг оновчтой, тасралтгүй, үр ашигтай зохион байгуулах эдийн засаг, эрх зүйн тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх

3.3. Хөтөлбөр хэрэгжүүлснээр хүрэх үр дүн

- Хүн амын унд ахуйн хэрэгцээ хангагдаж, ялангуяа малчид, говь хээрийн бүс нутгийн хүн амын амьдрах нөхцөл, соёлын түвшин дээшилнэ.
- Бэлчээр усжуулалтын үр дүнд мал аж ахуйн болон усалгаатай газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдэж, хүн амын хүнсний хангамж сайжирна.
- Байгалийн усны нөөцийг зохистой ашиглах, чанарыг хамгаалах удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагаа сайжирна.
- Усны нөөц байгалийн аясаар нөхөн сэргэх нөхцөлийг дэмжих, хомсдох, бохирдохоос хамгаалах арга ажиллагаа сайжирч, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын өнөөгийн түвшин дээшилнэ.
- Ус сувгийн зориулалттай барилга байгууламжид шинэ техник, технологи нэвтэрч тэдгээрийн ашиглалтын түвшин нэмэгдэнэ.
- Усны салбарын байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо, үйл ажиллагааны зохицуулалт сайжрах, усыг зохистой ашиглах, хамгаалах нэгдсэн бодлого хэрэгжих, түүнд зарцуулах хөрөнгийг зохистой хуваарилах, ашиглах нөхцөл бүрдэнэ.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛЫН ТОЙМ

4.1. Бодлого, шийдвэрүүд

Усны үндэсний хөтөлбөрийн үзэл санаа, үндсэн чиглэл Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын дараа дараагийн баримт бичгүүдэд тусгалаа олсноор хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын зохион байгуулалт, хөрөнгийн эх үүсвэр тодорхой болж зохих үр дүнд хүрэх нөхцөл бололцоо бүрджээ.

Тухайлбал, Улсын Их Хурлын 2003 оны 29 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын баримт бичигт хөдөө аж ахуйн усан хангамжийн талаар баримтлах бодлогыг дараах байдлаар тодорхойлон томъёолсон байна. Үүнд:

- Инженерийн болон энгийн уурхайн худаг, уст цэгийн тоог нэмэгдүүлэх, эзэмшил ашиглалтыг сайжруулахын зэрэгцээ усны нөөцийн бусад эх үүсвэрийг зохистой ашиглах замаар хүн ам, мал сүргийн усан хангамжийг нэмэгдүүлэх;
- Уст цэгүүдийг сэргээн засварлах, шинээр гаргах, цас борооны усыг хуримтлуулан хиймэл нуур, усан сан, хөв, цөөрөм бий болгох замаар бэлчээрийн усан хангамжийг сайжруулах;
- Шинээр уст цэг тогтоох хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх, усжуулалтын зориулалттай техник, тоног төхөөрөмж үйлдвэрлэх, иргэд аж ахуйн нэгжийн өөрсдийн хүч хөрөнгөөр уст цэг гаргах, засварлах, санал санаачлагыг дэмжих;
- Хадлангийн талбайг ашиглуулах, эзэмшүүлэх, бордох, услах үндсэн дээр байгаль, эдийн засгийн бус бүрт малын тэжээлийн хэрэгцээг дотоод нөөцөөр хангах нөхцөл бүрдүүлэх;
- Энгийн болон инженерийн хийцтэй услалтын системийн зураг төслийг өмчлөгч эзэмшигчийнх нь захиалгаар хийлгүүлж, түүнийг хэрэгжүүлэхэд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ ашиглалтыг сайжруулах, усалгааны бусад дэвшилтэт арга технологи /дуслын, нэвчилтийн систем болон усан сан, хөв байгуулах/-ийг нэвтрүүлэх замаар усалгаатай тариаланг хөгжүүлэх;
- Шинээр томоохон хэмжээний усалгаатай тариалан, хадлан бэлчээр бий болгох боломжтой газар нутгийн хайгуул, судалгаа, зураг төсөл боловсруулах, систем байгуулах ажлыг иргэн, аж ахуйн нэгжийн болон улсын захиалга, хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэх

Эдгээр нь усны аж ахуйн салбарт ойрын жилүүдэд баримтлах үндсэн бодлого чиглэл болж байгаа бөгөөд дээр дурдсан төрийн бодлогыг /2003-2008 онд/ хэрэгжүүлэх эхний үе шатны арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2003 оны 245 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Энэ төлөвлөгөөнд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор инженерийн хийцтэй 7500 худгийг засварлах буюу шинээр гаргах, орон нутаг, иргэдийн оролцоотойгоор 1500-аас доошгүй энгийн уурхайн худаг гаргах, цас, борооны усыг хуримтлуулан хиймэл нуур, усан сан, хөв, цөөрөм байгуулах цэгүүдийг тогтоох судалгааны ажил хийх, ус өргөх зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэх бага оврын цех, туршилт судалгааны төв байгуулах зэрэг асуудлуудыг хэрхэн шийдвэрлэхийг илүү нарийвчлан зааж өгчээ.

Түүнчлэн Засгийн газрын 2004 оны 57 дугаар тогтоолоор "Усны шинэтгэл-XXI" үйл ажиллагааны чиглэлийг батлаж усны нөөц, түүний ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, усны нөөцийн хайгуул, судалгааны ажлын өнөөгийн түвшинд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр Монгол Улсын Засгийн газраас ойрын 20 жилд усны талаар

явуулах үйл ажиллагаа, усны нөөцийг зохистой ашиглах усны сав газрын шинэ менежментийг бий болгон хөгжүүлэх чиглэлийг тодорхойлсон байна.

Монгол улсын газрын нэгдмэл сангийн 70.8 % буюу 110.2 сая га нь бэлчээрийн газар юм. Түүний 19.6 % нь худаг усны хүрэлцээ дутмаг байгаатай холбоотойгоор ашиглаж чадахгүй байгаа бэлчээр байна. Бэлчээрийн усжуулалтын талаар хийгдсэн суурь судалгаанаас харахад, улсын хэмжээний малчин өрхүүдийн /200 мянга орчим/ усан хангамжийг сайжруулж, бэлчээрийн 65.0 хүртэл %-ийг усжуулахад ойролцоогоор 10000 худаг шинээр гаргах хэрэгтэй гэсэн тооцоо гарчээ. 2002 онд хийсэн энэхүү тооцоогоор уг ажлыг гүйцэтгэхэд 60 гаруй тэрбум төгрөг шаардагдахаар байсан байна. Одоо худаг барьж байгуулах өртөг хэд дахин нэмэгдсэн байгаа. Шинээр гаргах худгийн 70 % буюу 7000 худаг нь 30 м хүртэл гүнтэй, 30 % буюу 3000 нь 30-м-ээс доош гүнтэй байх магадлалтай юм байна. Энэ зорилтыг доорх үе шатаар гүйцэтгэхээр ерөнхий төлөвлөлт хийсэн байна.

Хүснэгт 1.

Үе шат	Бүс нутаг	Шинээр гаргах худгийн тоо	Худгийн гүн /м/		Хугацаа /оноор/	Шаардагдах хөрөнгө /сая.төг/
			30 хүртэл	30-аас дээш		
Нэгдүгээр	Говь, тал хээрийн /7 аймаг/	3 500	2 450	1 050	2005-2010	20.650
Хоёрдугаар	Тал хээр, Хангайн /7 аймаг/	3 250	2 275	975	2010-2015	19.175
Гуравдугаар	Хангайн олон жилийн цэвдэгтэй /7 аймаг/	3 250	2 275	975	2015-2020	19.175
Нийт		10 000	7 000	3 000		59 тэрбум

2005 оны 7 дугаар сарын 15-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайд нар 101, 189, 194 дугаар хамтарсан тушаал гаргаж “Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам”-ийг батлан хэрэгжүүлсэн. Энэ нь худгийн ажлын гүйцэтгэгч, захиалагч, ашиглагч, эзэмшигчдийн хоорондын харилцааг зохицуулж эрх, үүргийг зааглаж өгсөн чухал ач холбогдолтой баримт бичиг юм.

4.2. Бэлчээрийн усжуулалт

Усны үндэсний хөтөлбөрийн 5 зорилтын 4-р зорилтоос бусад зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь ХХАА-н салбарт хамаарч байгаа. Хөтөлбөрийн хүрээнд ХХАА-н салбарт хийгдэж байгаа олон ажлуудын хамгийн өргөн далайцтай томоохон ажил нь бэлчээр, тариалангийн талбайг усжуулах чиглэлээр хийгдэж буй ажилууд юм. Улсын төсөв болон гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүжүүлж худаг, усалтын системүүдийг сэргээн засварлах, шинээр барьж байгуулах ажлыг 1998 оноос эхлэн орон даяар зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2006 оныг дуустал хугацаанд улсын төсвөөс 8837.5 сая төгрөг, гадаадын зээл тусламжаас 3706.6 сая төгрөг зарцуулжээ.

Энэ ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд буюу бэлчээрийн худаг, усалтын системийн талаарх тоон мэдээллүүдийг доорхи хүснэгтүүдээр харуулав.

Худаг шинээр гаргах, сэргээн засварлах ажилд зарцуулсан хөрөнгийн хэмжээ

Хүснэгт 2.

Он	Худаг шинээр гаргах ажилд зориулан улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Худгийн засварын ажилд зориулан улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Худгийн засварын ажилд зориулан гадаадын зээл тусламжаас зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Нийт
1998	-	238.0	-	238.0
1999	-	282.0	-	282.0
2000	-	260.0	-	260.0
2001	-	391.0	-	391.0
2002	-	515.0	70.4	585.4
2003	-	450.0	519.3	969.3
2004	250.0	428.0	989.6	1667.6
2005	200.0	400.0	1087.3	1687.3
2006	1500.0	1700.0	696.5	3896.5
Нийт	1950.0	4664.0	3363.1	9977.1

Улсын төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр засварласан болон шинээр гаргасан худгийн тоо

Хүснэгт 3.

Он	Улсын төсвийн хөрөнгөөр засварласан худгийн тоо	Улсын төсвийн хөрөнгөөр шинээр гаргасан худгийн тоо	Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр засварласан болон шинээр гаргасан худгийн тоо	Нийт
1998	167	-	-	167
1999	170	-	-	170
2000	157	-	-	157
2001	254	-	-	254
2002	284	-	20	304
2003	273	-	176	449
2004	213	37	359	609
2005	191	29	371	591
2006	563	180	238	981
Нийт	2272	246	1164	3682

1998-2006 онд улсын төсвийн хөрөнгөөр бэлчээрийн 2272 худаг сэргээн засварлаж, 246 худаг шинээр гаргаад байна. Мөн гадаадын төсөл, хөтөлбөрүүдийн шугамаар 1164 худгийг засварлаж, шинээр гаргаж ашиглалтанд оруулжээ. Өнгөрсөн 9 жилд нийтдээ улсын хэмжээгээр инженерийн болон энгийн уурхайн 3682 худаг шинээр ашиглалтад оруулснаар 5.5 сая га бэлчээрийг нэмж усжуулан 90 гаруй мянган иргэд, малчид, 10.0 сая гаруй малын усан хангамж сайжирсан байна.

Түүхийн баримт

Бэлчээрийг усжуулах, усалгаатай газар тариалан эрхлэх зорилгоор инженерийн хийцтэй 29.0 мянга гаруй, худаг, уст цэг, 17.0 мянган уурхайн худаг гарган нийт бэлчээрийн 64.5 %-ийг усжуулж, 50 орчим мянган га талбайг услах нийлбэр хүч чадалтай энгийн болон инженерийн хийцтэй 150 гаруй услалтын систем барьж байгуулсан түүх бий. Энэ үед хөдөө аж ахуйн усан хангамжийн түвшин үйлдвэрлэлийг тэтгэх хэмжээнд хүрсэн байлаа. Гэвч бэлчээрийн худгуудын барилга байгууламж, тоног төхөөрөмж тоногдон нийт худгийн 25 % нь устаж, 18 % нь ашиглах боломжгүй болон орхигдсоноос инженерийн хийцтэй худаг 8.2 мянга болтлоо цөөрсөн байна.

4.3. Тариалангийн усжуулалт

Төрөөс хэрэгжүүлсэн бодлого, дэмжлэгийн үр дүнд усалгаатай тариалангийн талбайн хэмжээ байнга өсөн нэмэгдсээр байна. 2000 онд 5.6 мянган га талбайд усалгаатай тариалан эрхэлж байсан бол 2001 онд 6.4 мянган га, 2002 онд 7.2 мянган га, 2003 онд 7.1 мянган га, 2004 онд 15.4 мянган га, 2005 онд 17.8 мянган га, 2006 онд 19.3 мянган га болж өсчээ.

Шинээр барьсан, сэргээн засварласан услалтын систем болон зарцуулсан хөрөнгийн хэмжээ

Хүснэгт 4.

Он	Сэргээн засварласан услалтын систем						Шинээр барьсан услалтын систем	
	тоо	Хүч чадал /га/	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/				тоо	Хүч чадал /га/
			Улсын төсвөөс	Гадаадын зээл, тусламжаас	Өөрийн хөрөнгөөс	Нийт		
2003	-	-	-	262.8*	-	262.8	4	750
2004	11	2837	800.0	80.9	1352.9	2233.8	-	-
2005	14	2304	653.6	-	619.2	1272.8	-	-
2006	12	3500	769.9	-	575.4	1345.3	15**	2560
Нийт	37		2223.5	343.7	2547.5	5114.7	4	750

2003 онд "Хүнс, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл - шинэ технологи сан", Азийн хөгжлийн банкны "Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн төсөл", Европын холбооны ТАСИС хөтөлбөрийн "Мал аж ахуй, газар тариалан хосолсон төсөл"-ийн хүрээнд 262.8 (*) сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, 750 га талбайг услах хүч чадалтай 4 услалтын системийг шинээр барьсан байна.

Улсын төсвөөс 2004 онд 800.0 сая төгрөг зарцуулж 2837 га талбайг усжуулах хүч чадалтай 11 услалтын системийг, 2005 онд 653.6 сая төгрөг зарцуулж 2304 га талбайг услах хүч чадалтай 14 услалтын системийг, 2006 онд 770.0 сая төгрөг зарцуулж 3500 га талбайг услах хүч чадалтай 12 услалтын системийг тус тус ашиглалтанд оруулснаар усалгаатай тариалангийн хэмжээг 8641 га-аар нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн байна. Үүнээс гадна 2006 онд 2560 га услах хүч чадалтай 15 (***) услалтын системийг шинээр барихад зориулан Япон улсын КР-1 төслийн хуримтлалын сангаас 2.0 тэрбум төгрөг зээлээр олгосон байна.

Газар тариалангийн усжуулалтад 2003-2006 онд улсын төсөв болон бусад эх үүсвэрүүдээс нийт 4567.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж 60 гаруй аж ахуйн нэгжийн 37 услалтын системийг сэргээн засварлаж 4 систем шинээр барьж ашиглалтад оруулжээ. Энэ бүхний үр дүнд усалгаатай тариалангийн хэмжээ 2000 онд 5585.4 га байсан бол 2006 онд 19274.7 га болж 3.45 дахин нэмэгдсэн байна.

Усалгаатай тариалан эрхэлсэн талбай, хураан авсан ургацын хэмжээ

Хүснэгт 5.

	Он			
	2000	2004	2005	2006
Тариалсан талбай /га/	5585.45	15359.3	17700.0	19274.7
Үүнээс:				
Үр тариа	3631.5	4463.7	4080.0	4980.1
Төмс	330	5111.8	6497.0	5501.6

Хүнсний ногоо	708.25	4247.1	5243.0	5140.22
Жимс, жимсгэнэ	153.0	250.7	176.0	221.4
Малын тэжээл	746.7	1148.4	1641.0	1357.2
Бусад	16.0	137.6	138.0	515.5
Хураасан ургац /цн/	12409	109838.3	133843.9	138344.3
Үүнээс:				
Үр тариа	2734.7	9546.0	3250.0	6259.1
Төмс	1919.2	51806.6	66014.0	58729.0
Хүнсний ногоо	6788.4	43779.6	58988.0	69030.9
Жимс, жимсгэнэ	34.0	1280.8	225.5	102.4
Малын тэжээл	877.7	3238.6	5366.4	3676.3
Бусад	55.0	186.7		546.6
1 га-ийн ургац /цн/	22.22	71.51	75.6	71.7
Үүнээс:				
Үр тариа	7.53	21.39	7.9	12.5
Төмс	58.16	101.35	101.6	106.7
Хүнсний ногоо	95.85	103.08	112.5	134.2
Жимс, жимсгэнэ	2.22	51.09	1.4	4.6
Малын тэжээл	11.75	28.20	32.7	27.0
Бусад	34.38	13.57		10.6

Түүхийн баримт

1990 оны байдлаар инженерийн хийцтэй бороожуулан услах талбай 45.0 мян.га, гадаргуугийн аргаар услах талбай 16.0 мян.га болж улсын хэмжээгээр жимс жимсгэнэ, хүнсний ногоог 100%, төмсний 20%, таримал тэжээлийн 15-18%, үр тарианы 2.5%-ийг усалгаатай талбайгаас бэлтгэж байсан байна. Энэ үед усалгаатай тариалан нийт ус хэрэглээний 46.2 %-ийг, аж үйлдвэрийн салбар 19.4 %-ийг, хүн амын унд ахуйн хэрэглээ 13.4 %-ийг тус тус эзэлж байжээ. Эднээс хөдөө аж ахуйн ус хэрэглээ хамгийн их хэмжээтэй байгаа нь харагдаж байна.

Ус ихээхэн хэмжээгээр хэрэглэж байсан 1986-1990 онд хамгийн их ургац авч байсан бөгөөд жилд дунджаар үр тариа 770.0 мянган тонн, төмс 127.0 мянган тонн, хүнсний ногоо 46.0 мянган тонныг бэлтгэн хүн амынхаа гурил, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, илүүдэл бүтээгдэхүүнээ экспортолж байжээ.

1986-1999 онуудад инженерийн хийцтэй усалтын системээс хураан авсан хамгийн өндөр ургацын дүнг жишээ болгон авч үзвэл 1987 онд үр тариа 22.8 цн, таримал тэжээл 48.2 цн, 1990 онд төмс 154 цн, хүнсний ногоо 187.4 цн, 1998 онд жимс жимсгэнэ 23.8 цн-ийг тус тус хураан авч байжээ. Энэ үр дүн хэрвээ технологийг эзэмшиж чадвал усалгаатай талбайгаас хэрэгцээтэй бүтээгдэхүүнээ авах боломжтойг батлан харуулж байгаа юм.

ТАВ. 2007 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

5.1. Бэлчээрийн усжуулалтын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил

2007 онд шинэ худаг барьж байгуулах ажлын дундаж өртгийг 9.0 сая төгрөгөөр тогтоосон байна. Энэ өртөгт уст цэгийн хайгуул, 50 м гүнтэй худгийн цооног, ус шахуурга, цахилгаан үүсгүүр, худгийн барилга, мал услах онгоц, 1м³ –ээс дээш багтаамжтай усан сан зэргийг барьж байгуулахаар тооцжээ.

- 50 м гүнтэй цооног өрөмдөх үнэ 5.0 сая төгрөг,
- Уст цэгийн хайгуул, тээврийн зардлын хамт 500.0 мянган төгрөг,
- Ус шахуурга, цахилгаан үүсгүүрийн хамт 1.2 сая төгрөг,
- Худгийн барилга, мал услах онгоцийн хамт 1.1 сая төгрөг,
- 50 м гүнтэй цооногт суулгах суултын яндан, шүүрийн хамт 1.2 сая төгрөг

Хэрэв худгийн гүн 70 м байвал өрөмдлөгийн ажлын өртөг 7.0 сая болж нэмэгдэх хэдий 30 м бол 3.0 сая болж буурах тул төлөвлөсөн ажлыг төсөвт зардалд багтааж гүйцэтгэх боломжтой юм байна. Нэг худаг барьж байгуулахад орон нутгийн захиргаа, малчид, хоршооны оролцооны хөрөнгө нь сэргээн засварлах худагт нийт үнийн дүнгийн 10 %-аас доошгүй, шинээр гаргах худагт 5 %-аас доошгүй байна гэсэн журмын заалтыг 2005 оноос мөрдөж эхэлсэн боловч хэвшил болж тогтворжиж чадаагүй байна. Энэхүү оролцооны хөрөнгийг худгийн барилга барихад нэмж оруулдаг журамтай.

2007 онд худаг сэргээн засварлахад зориулж 1.5 тэрбум, худаг шинээр гаргахад зориулж 7.7 тэрбум төгрөгийн хөрөнгө батлагджээ. Түүнээс гадна улсын төсвийн тодотголоор 2.5 тэрбум төгрөгийг худаг шинээр гаргах, сэргээн засварлах ажилд зориулахаар нэмж батлагдсан байна. Үүний зэрэгцээгээр бэлчээрт шинэ уст цэг тогтоох хайгуулийн ажил явуулах болон услалтын системийн зураг төсөл зохиох зориулалтаар 300.0 сая төгрөг улсын төсвийн тодотголоор нэмж батлагджээ.

Нийт 12.0 тэрбум төгрөг зарцуулан хийгдэх дээрх ажлыг 4 багц болгон төлөвлөж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- **Нэгдүгээр багц:** Анх төсөвлөгдсөн хөрөнгийн 90% буюу 8280.0 сая төгрөгийн 1350.0 сая төгрөгөөр 386 худаг сэргээн засварлуулах, 6930.0 сая төгрөгөөр 770 худаг шинээр гаргуулах
- **Хоёрдугаар багц:** Анх төсөвлөгдсөн хөрөнгийн 10% буюу 920.0 сая төгрөгөөр отрын бүс нутаг болон Улаанбаатар хотод 102 худаг шинээр гаргуулах /ХХАА-н сайдын 2007 оны 92 дугаар тушаал/
- **Гуравдугаар багц:** 2007 оны 8 дугаар сард Улсын төсвийн тодотголоор батлагдсан 2.5 тэрбум төгрөгөөр худаг шинээр гаргах, сэргээн засварлуулах /Энэ ажлыг шуурхай зохион байгуулан тендер шалгаруулах зааварчилгааг бүх аймгийн засаг дарга нарт хүргүүлсэн байна./
- **Дөрөвдүгээр багц:** Улсын төсвийн тодотголоор батлагдсан 300.0 сая төгрөгийн 220.0 сая төгрөгөөр Архангай, Хөвсгөл, Завхан, Ховд, Хэнтий, ГовьСүмбэр, Говь-Алтай, Төв аймагт газрын доорх усны геофизикийн хайгуулын ажил гүйцэтгүүлэх, 80.0 сая төгрөгөөр услалтын системийн зураг төсөл зохиолгох

**2007 онд улсын төсвөөр батлагдсан хөрөнгийн хуваарь,
худаг гаргах ажлын төлөвлөлт**

Хүснэгт 6.

№	Аймаг	Засварлах худгийн		Шинээр гаргах худгийн		Нийт	
		өртөг /сая.төг/	Тоо	өртөг /сая.төг/	Тоо	өртөг /сая.төг/	Тоо
1	Архангай	54	15	270	30	324	45
2	Баянхонгор	45	13	270	30	315	43
3	Баян-Өлгий	45	13	270	30	315	43
4	Булган	54	15	270	30	324	45
5	Говь-Алтай	90	26	270	30	360	56
6	Дорноговь	90	26	450	50	540	76
7	Дорнод	90	26	450	50	540	76
8	Дундговь	90	26	450	50	540	76
9	Дархан-Уул	45	13	180	20	225	33
10	Завхан	90	26	360	40	450	66

11	Өвөрхангай	72	21	270	30	342	51
12	Өмнөговь	90	26	450	50	540	76
13	Сүхбаатар	90	26	450	50	540	76
14	Сэлэнгэ	0	0	180	20	180	20
15	Орхон	0	0	180	20	180	20
16	Төв	90	26	360	40	450	66
17	Увс	90	26	360	40	450	66
18	Ховд	90	26	360	40	450	66
19	Хөвсгөл	45	13	360	40	405	53
20	Хэнтий	45	13	360	40	405	53
21	Говь-Сүмбэр	0	0	180	20	180	20
22	Улаанбаатар	45	13	180	20	225	33
23							
Нийт дүн		1350	389	6930	770	8280	1159

2007 онд худаг шинээр гаргах ажлын гүйцэтгэл			
Төлөвлөлт		Гүйцэтгэл	
Зардал /сая.төг/	Худгийн тоо		
7850.0+	872+...	Улаанбаатар хот болон 21 аймгаас шалгарсан 48 гүйцэтгэгчтэй 124 гэрээ байгуулан улсын төсвийн 9.9 тэрбум төгрөгөөр 1041 худгийг шинээр гаргуулж барьж байгуулуулан ашиглалтанд хүлээн авсан.	
...			
Худаг шинээр барьж байгуулах ажлын			
Нийт зардал		
Оролцооны хөрөнгө		
Улсын төсвөөс		
Зөрүү	 /үлдэгдэл, хэмнэлт/	
2007 онд худаг сэргээн засвалах ажлын гүйцэтгэл			
Төлөвлөлт		Гүйцэтгэл	
Зардал /сая.төг/	Худгийн тоо		
1350.0	386+...	Улаанбаатар хот болон 19 аймгаас шалгарсан 24 гүйцэтгэгчтэй 28 гэрээ байгуулан улсын төсвийн 1.3 тэрбум төгрөгөөр 407 худгийг сэргээн засварлуулж ашиглалтанд хүлээн авсан.	
Худаг шинээр барьж байгуулах ажлын			
Нийт зардал		
Оролцооны хөрөнгө		
Улсын төсвөөс		
Зөрүү	 /үлдэгдэл, хэмнэлт/	
Нийт 11.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1448 худгийг ашиглалтанд хүлээн авсан нь төлөвлөгөөт үзүүлэлттэй харьцуулахад 98.0 %-ийн биелэлттэй байна.			
1448 худгийг ашиглалтанд хүлээж авснаар хот, хөдөөгийн 3000 мянга гаруй хүний усан хангамж сайжрах, 40.0 мянган га бэлчээр усжуулагдаж 5.0 сая гаруй мал усаар хангагдах нөхцөл бололцоог бүрдүүлжээ.			
160 сая төгрөгийн хөрөнгөөр Архангай, Хөвсгөл, Завхан, Ховд, Хэнтий, ГовьСүмбэр аймагт газрын доорх усны геофизикийн хайгуулын ажлыг гүйцэтгэж нийт 166 устай цэгийг тогтоолгосон.			

Бэлчээрт худаг шинээр барьж байгуулах, сэргээн засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг аймгуудад бүрэн шилжүүлсэн нь гүйцэтгэгч, захиалагч, хэрэглэгчдийн хоорондын идэвхтэй харилцааг дэмжих чухал хүчин зүйл болжээ. Мөн бэлчээр усжуулалтын ажлыг орон нутагт зохион байгуулахад мөрдөх журмыг 2005 онд гаргаж хэрэгжүүлж эхэлсний зэрэгцээ тухайн жилд анхаарах асуудлуудын талаар жил бүр заавалчилгаа өгч ажилладаг байна.

2007 онд хэрэгжүүлсэн техник технологийн шинэчлэлийн бодлогын хүрээнд ус шахуурга болон цахилгаан үүсгүүрт тавигдах шаардлагыг тодорхой болгож зааварчилгаа өгчээ. Түүний дагуу энэ оноос аймаг орон нутгийн удирдлагууд тендер зарлахдаа

худгийг ус шахуурга, цахилгаан үүсгүүрүүдэд дараах техникийн шаардлагыг тавьж эхэлжээ.

- Барааны олон улсын ISO-9001 стандарт,
- Барааны гарал үүслийн тодорхойлолт,
- Нийлүүлэгч компанийн бараа үйлдвэрлэх эрхийн бичиг,
- Нийлүүлэх барааны техникийн үзүүлэлтийг нотолсон хэвлэмэл танилцуулга, ашиглалтын заавар,
- Монгол хэл рүү орчуулж бэлтгэсэн ашиглалтын заавар

Монгол малчид жилд олон удаа нүүдэл хийдэг тул бэлчээрийн зарим худгийг ашиглах хугацаа маш богино байна. Ийм тохиолдолд ус шахуургыг худгийн цооног дотор орхиж удаан хугацаагаар байлгавал ус өргөх яндан хоолой зэвэрч улмаар ус шахуургын бүрдэл хэсгүүдийн илэгдэл түргэсдэг. Иймээс гүйцэтгэгч нар худгийн эзэмшигч нарт зориулсан ашиглалтын зааврыг боловсруулахдаа үүнээс сэргийлэх зөвлөмжийг заавал оруулах хэрэгтэй гэсэн зааварчилгааг мөн шинээр өгчээ.

Энэ оноос хөрөнгө хэмнэлтийн оновчтой бодлого баримталахыг зөвлөсөн байна. Бэлчээрийн мал аж ахуйн онцлогтой холбоотойгоор малчид жилдээ хэд хэдэн удаа нүүдэл хийдэг тул бэлчээрийн худагт ноогдох ачаалал харьцангуй бага байдаг. Иймд 3000 мал ус уух худагт 5 л/с ундрагатай байх ус шахуурга тавьж түүнд нь тохирсон цахилгаан үүсгүүр сонговол үр ашиггүй зардал маш их гарна. Тиймээс энэ асуудлыг шинжлэх ухааны үндэстэй тооцоолон 0.6 л/с-ээс 2 л/с ундрагатай байх хэмжээний ус шахуурга шаардахыг зөвлөсөн байна. Ийм ундрагатай худгийг өдөрт 8 цаг ажиллуулахад 4000 малыг усалж чадах юм байна.

Эрүүл мэндийн яамны шугамаар хэрэгжиж байгаа Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд 6 аймагт 28 ширхэг “CLEAN CAPE” төхөөрөмжийг суурилуулан шинэ техник, технологи нэвтрүүлэх туршилтийг хийж эхэлсэн байна. Энэ төхөөрөмж нь:

- Худгийн цооног доторх усыг улирлын хөлдөлтөөс хамгаалсан,
- Худгийн барилга барих шаардлага байхгүй,
- Цооногийн амсар хэсэг бат бөх ямар нэгэн халдлагад өртөхгүй,
- Цооног доторх эд анги, ус шахуурга зэргийг солиход хялбар,
- Олон цооногт суурилуулж усны түвшин, усны чанар, бусад олон үзүүлэлтийг алсын удирдлагаар хянах бүрэн боломжтой,
- Ариун цэврийн шаардлага бүрэн хангасан
- Хөрсний бохирдлоос хамгаалсан зэрэг давуу талуудтай юм.

Бэлчээрт шинээр худаг барьж байгуулах, сэргээн засварлах ажлыг илүү үр дүнтэй зохион байгуулахад анхаарах шаардлагатай хэд хэдэн асуудал байна.

Гүйцэтгэгч компаниуд ус шахуурга, цахилгаан үүсгүүр зэргийг тус тусдаа нийлүүлж байгаа нь цаг хугацаа алдах, үргүй зардал их гарах, чанарын шаардлага хангахгүй байх зэрэг бэрхшээл үүсгэж байгаагаас гадна өөр хоорондоо ялгаатай олон нэр төрлийн техник орж ирэх нөхцөл байдлыг үүсгэжээ. Энэ нь эвдрэл гарсан үед засварлах, сэлбэг хэрэгсэлээр хангах үед шийдвэрлэхэд түвэгтэй сөрөг үр дагаварыг буй болгож байгаа юм. Дорнод аймгийн хувьд хүчин чадал сайтай орон нутгийн аж ахуйн нэгж дангаараа үйл ажиллагаа явуулж байгаа тул сэлбэг болон засварын үйлчилгээний бэрхшээл байхгүй байна. Ихэнх аймгуудад тухайн аймагт суурин байдаггүй хэд хэдэн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байгаа төдийгүй жил бүр өөрчлөгдөж байна. Ийм тохиолдолд сэлбэг хэрэгсэл, засварын үйлчилгээ ихээхэн бэрхшээлтэй тулгарч байгаа

юм. Иймээс сайн чанарын ус шахуурга, цахилгаан үүсгүүрийг олноор нь нийлүүлэн сэлбэг хэрэгсэлээр хангах, техникийн байнгын үйлчилгээ үзүүлэх үйлчилгээг бий болгох зохистой хувилбарыг санаачлан хэрэгжүүлж эхлэх шаардлагатай байна.

Хөтөлбөрийн эхний жилүүдэд аль ч аймагт ажил гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд ашиглалтгүй болсон хуучин худгуудын мал услах онгоц, талбайн болон дулаалгын овоолгын хавтан, бусад угсармал төмөр бетон хийцүүдийг зөөвөрлөн ашиглаж байлаа. Өнөөдөр нөөц шавхагдан дууссан байна. Иймээс тэд янз бүрийн материалаар орлуулах, газар дээр нь цутгах аргыг ашиглаж эхэлсэн байна. Аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэх түүхий эдээ тохируулан сонгох туршлага багатай байгаагаас гадна уурын хатаалгатай өндөр технологээр үйлдвэрлэх боломжгүй байгаа тул чанарын хувьд төдийлөн бат бөх байж чадахгүй байна. Барилгын цементээ зөв сонгож чадаагүйн улмаас цутгамал бетонууд нь задран нурсан, хуучин онгоцнуудын залгаасны шавар нь үйрч унасан зэрэг дутагдлууд Орхон, Архангай аймагт тохиолдож байлаа.

Мөнх цэвдэгтэй газар худаг гаргасан тохиолдолд худгийг тогтмол ашиглаж усыг байнгын эргэлттэй байлгаж чадахгүй бол хөлддөг байна. Бэлчээрийн худаг бол байнгын ашиглалтанд байх боломжгүй. Гэтэл төвийн цахилгаан эрчим хүчээр хангагдаагүй, худгийг хөлдөлтөөс хамгаалах төхөөрөмж тавих боломжгүй Хөвсгөл аймгийн мөнх цэвдэгтэй сумдуудад орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүд нь төсөв хуваарилж, гүйцэтгэгч байгууллага нь худаг гарган эрсдэлтэй үйл ажиллагаанд мөнгө зарцуулсан байна. Энэ нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч зарим байгууллагууд мөнгө л авч байвал хаана ч, юу ч хамаагүй хийхэд бэлэн байгаа сэтгэлгээний хоцрогдлын нэгэн жишээ юм.

Худгийн цооног өрөмдлөгийн болон шавхалт, туршилтын технологийг чанд мөрдүүлэхэд хэрэглэгчид, орон нутгийн удирдлагын зүгээс хяналт хангалтгүй байгаагаас шинээр барьж байгуулсан зарим худаг ашиглалтын шаардлага хангахгүй байгаа тохиолдол байна. Ийм дутагдал бидэнтэй Архангай, Булган аймагт явж байхад тохиолдсон байгаа. Хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг асуудлыг журмын 4.3., 4.4. дэх заалтуудаар тодорхой зохицуулж өгсөн хэдий ч үр дүнтэй хэрэгжихгүй байна. Журамд зааснаар худгийн захиалга өгөх үед л тухайн худгийг хэн хариуцан эзэмших вэ гэдэг нь тодорхой болсон байх ёстой. Энэ ажлын эцсийн үр шимийг хүртэгчид болох малчид хамгийн идэвхтэй хяналт тавих боломж бий. Бэрхшээл тоочих дуртай дарга нар хяналт тавихын тулд тусгай мэргэжил эзэмших хэрэгтэй мэт ярьдаг. Өрөмдлөг хийж байхад өдөр бүр очоод, асууж шалаад, яндан хоолойг нь тоолоод сууж байсан малчин Архангай аймгийн Хашаат суманд бидэнтэй уулзсан. Тэр шинэ худаг гаргах ажлыг маш чанартай гүйцэтгүүлж чадсан байна. Энэ нь орон нутаг дахь зохион байгуулалтаас хамаарах зүйл гэдэг нь эндээс харагдаж байна.

Худаг эмэмшигч, хэрэглэгчдийн идэвхтэй харилцааг дэмжих зорилгоор 2005 оноос мөрдөж эхэлсэн журамд оролцооны хөрөнгө гаргах тухай заалт оруулсан байгаа. Гэвч нийт сумдын бараг тал хувьд нь энэ асуудал төлөвшин тогтворжиж чадаагүй байна. Энэ нь сум, багийн удирдлагын идэвх санаачлагагүй, урагшгүй, арчаагүй байдалтай шууд холбоотой юм. Тухайн оны ажил дөнгөж эхлэх үед оролцооны хөрөнгийг цуглуулчихсан сумын удирдлага байхад өмнөх жилийн асуудлаа ч шийдвэрлэж чадаагүй зовлон тоочоод сууж байгаа сумын удирдлага цөөнгүй таарч байна.

Их хэмжээний хөрөнгө хүч зарцуулан байж бүтээн босгосон худаг, уст цэг, усны барилга байгууламжийн засвар үйлчилгээг цаашид ашиглагч, эзэмшигч нь өөрсдөө хариуцаж явах ёстой. Энэ талын ойлголт, мэдээллийг хүмүүст сайтар хүргэх тал дээр сум, багийн удирдлагууд ч, мэргэжилтнүүд ч хангалттай ажиллаж чадаагүй байна.

Газрын доорх усны эрэл хайгуул, усны судалгаа шинжилгээний ажил сүүлийн жилүүдэд орхигдсоноос шинэ бэлчээр, зэлүүд газар ус гаргах ажил зогсонги байдалд орсон гэж судлаачид дүгнэжээ. Ийнхүү шинээр уст цэг гаргах ажил аз туршсан эрсдэлтэй асуудал болсон тул хуучин худгийн цооногтой зэрэгцүүлэн өрөмдөж шинэ худаг гаргах арга хэлбэр түгээмэл байна. Энэ нь цаашдаа илүү хэрэгцээтэй газраа худаг гаргаж чадахгүй үлдэх нөхцөл байдалд хүргэж болзошгүй юм.

Дэлхийн уур амьсгалын дулаарал, монгол оронд тохиолдож буй олон жилийн ган зэргээс шалтгаалсан хуурайшилттай холбоотойгоор хөрсний өнгөн хэсгийн усыг хялбар аргаар олборлож ашиглах нөөц үндсэндээ шавхагдсан учир 30 м ба түүнээс гүнд орших газрын доорхи усны нөөцийг ашиглах шаардлага тулгараад байна. Энэ нь төсөв зардлыг төлөвлөхдөө анхаарах чухал асуудлуудын нэг юм.

ХАА-н усан хангамж, усны нөөцийн ашиглалтын талаар мэдээллийн сан бүрдүүлэх бэлтгэл хангаж мэдээллийн баазыг Excel програм дээр оруулсан байгаа юм байна. Түүнд боловсруулалт хийж зураглалд оруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран гүйцэтгэж, бэлчээр усжуулалтын мэдээллийн мониторингийг шинэ шатанд гаргах ажлыг ирэх онд амжуулах хэрэгтэй байна.

5.2. Тариалангийн усжуулалтын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил

Усалгаатай тариаланг нэмэгдүүлэх зорилгоор 2007 онд 2.0 тэрбум төгрөг төсөвлөгдсөн бөгөөд услалтын систем шинээр барихад зориулан 1.2 тэрбум, сэргээн засварлахад зориулан 800.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Дээрх төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулснаар 14 услалтын системийг сэргээн засварлаж 1620.4 га, 10 услалтын системийг шинээр барьж 1199.7 га, нийт 2820.1 га талбайг шинээр усжуулжээ.

Шинээр барьж ашиглалтанд оруулсан услалтын системүүд

Хүснэгт 7.

№	Аймаг	Сум	Услалтын системийн нэр	Хүч чадал /га/
2006 оны гэрээнээс				
1	Сэлэнгэ	Цагааннуур	Бор бэлчир	62.4
2	Сэлэнгэ	Түшиг	Хар горхи	55.6
3	Архангай	Хотонт	Цагаан сүмийн гол	121.3
4	Дорнод	Хэрлэн	Зүүн ерөө	308.0
5	Сэлэнгэ	Зүүнбүрэн	Бонгийн тохой	330.0
6	Сэлэнгэ	Мандал	Орхироогийн адаг	90.0
Дүн				967.3
2007 оны гэрээнээс				
1	Сэлэнгэ	Цагааннуур	Соогооч	150.0
2	Сэлэнгэ	Зүүнбүрэн	Могой зуу	84.0
3	Сэлэнгэ	Хушаат	Мандлын булан	82.5
4	Төв	Батсүмбэр	Баянтолгой	136.0
5	Сэлэнгэ	Зүүнбүрэн	Чацаргана	104.0
6	Сэлэнгэ	Хушаат	Орхон –Хушаат	165.9
7	Сэлэнгэ	Зүүнбүрэн	Эрхэтийн нуга	99.5
8	Сэлэнгэ	Түшиг	Гурван толгой	100
9	Сэлэнгэ	Ерөө	Шинэстэй	178.8
10	Хэнтий	Хэрлэн	Хэрлэн	99.0

Дүн		1199.7
-----	--	--------

2560 га услах хүч чадалтай 15 услалтын системийг шинээр барихад зориулан Япон улсын КР-1 төслийн хуримтлалын сангаас 2006 онд олгосон 2.0 тэрбум төгрөгний зээлээр гүйцэтгэсэн ажлыг 2007 оны 5 сарын 15-ны дотор ашиглалтанд хүлээн авах гэрээтэй байсан боловч нь дөнгөж 967.3 га услах хүч чадалтай 6 услалтын системийг хүлээн авч ашиглалтанд оруулан, тэдгээрт 1605.1 сая төгрөг зарцуулсан байна.

2007 онд улсын хэмжээгээр 25.4 мянган га талбайд усалгаатай тариалан эрхэлж, үр тариа 5391.3 га, төмс 7040.7 га, хүнсний ногоо 5717.2 га, жимс, жимсгэнэ 193.8 га, малын тэжээл 6887га, бусад таримал 198.6 га талбайд тариалсан байна. Энэ оны үзүүлэлтийг 2003 оныхтой харьцуулвал 3.56 дахин өссөн байна. Улсын хэмжээгээр тариалсан нийт талбайн 12.8 %-ийг усалгаатай тариалан эзэлж байгаагийн дотор үр тарианы талбайн 4.4 %, төмсний талбайн 60.5 %, хүнсний ногооны талбайн 92.6 %, малын тэжээлийн талбайн 97.3 % нь усалгаатай байна.

Усалгаатай талбайгаас 2007 онд үр тариа 10330.2 тн, төмс 77581.5 тн, хүнсний ногоо 74777 тн, жимс, жимсгэнэ 185.0 тн, малын тэжээл 21279.0 тн хураан авлаа. Энэ нь улсын хэмжээгээр хураан авсан үр тарианы 9.1 %, төмсний 68.1 %, хүнсний ногооны 94.5 % болж байна.

Усалгаатай 1 га талбайгаас дунджаар үр тариа 19.2 цн, төмс 110.0 цн, хүнсний ногоо 131.0 цн, малын тэжээл 30.9 цн хураан авсан нь улсын дундаж ургацаас үр тариа 10.0 цн-ээр, төмс 12.2 цн-ээр, хүнсний ногоо 2.8 цн-ээр, малын тэжээл 19.7 цн-ээр тус тус илүү байна. Нэг га-гийн ургацыг өнгөрсөн 2006 оны үзүүлэлттэй харьцуулахад үр тариа 6.7 цн-ээр, төмс 3.3 цн-ээр, малын тэжээл 11.2 цн-ээр нэмэгдэж, харин хүнсний ногоо 3.2 цн-ээр буурсан байна.

Усалгаатай тариалангийн хэмжээ, ургац

Хүснэгт 8.

Үзүүлэлт	Он	Үүнээс					
		Үр тариа	Төмс	Хүнсний ногоо	Жимс, жимсгэнэ	Малын тэжээл	бусад
Талбайн хэмжээ /га/	2006	5391.3	7040.7	5717.2	193.8	6887.0	198.6
	2007						
Хураан авсан нийт ургац /цн/	2006						
	2007	10330.2	77581.5	74777.0	185.0	21279.0	-
Нэг га-гийн ургац /цн/	2006						
	2007	19.2	110.0	131.0	-	30.9	-

2007 онд усалгаатай тариалангийн нийт ургацын хэмжээ 2006 оныхоос үр тариа 1.7 дахин, төмс 1.3 дахин, хүнсний ногоо 1.1 дахин малын тэжээл 8.0 дахин нэмэгдсэн байна. Монгол Улсын Их Хурлаас 2003 онд баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-д усалгаатай тариалангийн хэмжээг 2008 оны эцэст 2003 оныхоос 2.5 дахин нэмэгдүүлэх зорилт тавьжээ. Гэтэл 2007 онд усалгаатай тариалангийн хэмжээ 25428 га болж 2003 оныхоос даруй 3.56 дахин өссөн байна.

Услалтын систем шинээр барих, сэргээн засварлах ажил хугацаандаа дуусахгүй байгаа, гүйцэтгэсэн ажил чанарын шаардлага хангахгүй байгаа, ашиглалтанд хүлээж авсан услалтын систем ашиглагдахгүй байгаа зэрэг нэн даруй засаж залруулах шаардлагатай

байгаа дутаглууд олон байна. Тухайлбал, 2004 онд улсын төсвийн дэмжлэг авч Төв аймгийн Борнуурын услалтын системийг засварласан “Эр Ши Жу” ХХК, Сэлэнгэ аймгийн Цагаантолгойн услалтын системийг засварласан “Ти Си Агро” ХХК зэрэг олон компаниуд ажлаа дутуу хийснээс хугацаанд нь хүлээн авч ашиглалтанд оруулж чадаагүй, Орхон аймагт Хангал гол дээр нягтруулагагүй далан барьж байсан, Улаанбаатар хотын "Алтан газар" хоршоо 2004 онд, Говь-алтай аймгийн "Атас эрдэнэ" ХХК, Салхин Сандаг" хоршоо 2005 онд төрийн дэмжлэгтэйгээр услалтын системээ сэргээн засварласан атлаа ашиглалтгүй байлгасаар байгаа зэрэг дутагдал зөрчлүүд хэвлэлд тэмдэглэгдсэн байна. Сүүлийн 2 жилийг авч үзэхэд 2006 онд 2560 га талбайг услах хүч чадалтай 15 услалтын системийг шинээр барихаар гэрээ хийсэн боловч 967.3 га талбайг услах хүч чадалтай 6 услалтын систем, 2007 онд 1285 га талбайг услах 11 услалтын системийг шинээр барихаар гэрээ хийсэн боловч 199.7 га талбайг услах хүч чадалтай 10 услалтын системийг ашиглалтанд оруулсан байна.

Услалтын системийн захиалга, гүйцэтгэл, эзэмшилт, ашиглалтын талаар яамнаас гаргасан бодлогын баримт бичиг, заавар журам, техникийн нөхцөл, гарын авлага хангалтгүй байна. Нэн түрүүнд тусгай журам гаргаж, услалтын системийн гүйцэтгэл, эзэмшилт, ашиглалтын үеийн харилцааг тодорхой болгон захиалагч, гүйцэтгэгч, эзэмшигчийн хэн буруутай нь хариуцлага хүлээж, үүссэн хохиролыг барагдуулдаг механизмийг хэрэгжүүлж эхлэхгүй бол их хэмжээний хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах дутагдал цаашид ч үргэлжлэх төлөвтэй байна. Дээрх үйл ажиллагаанд мэргэжлийн төрийн ба төрийн бус байгууллагуудыг татан оролцуулж хамтран ажиллах хэрэгтэй юм.

Өвөл болж ус хөлдөж, цас орсон хойно услалтын систем хүлээн авна хэмээн явж байсан тохиолдол цөөнгүй байлаа. Жилийн дулаан улиралд хайгуул судалгаа хийх, зураг төслийг аажуу тайван хийх боломжийг хангаж ажиллах талаар бодлого хэрэгжүүлэгч нэгж анхаарах шаардлагатай. Өөрөөр хэлбэл ирэх оны тендерийг өмнөх оны дулааны улиралд зарлаж байвал ажилд ахиц гарах боломж бүрдэх юм.

Услалтын системийн барилга байгууламжийн зураг төсөлд эдийн засгийн нарийн үндэслэл тооцоо хийгдсэн байх ёстойгоос гадна шинэ техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга замыг заасан гол хэрэгсэл болж байх ёстой. Гэтэл сүүлийн үед ерөнхий төлөвлөгөөгүй, талбайн хил хязгаарыг заагаагүй, ашигтай ба услан ургац авах хэмжээг гаргаагүй зэргээр үндэслэл, тооцоо муутай, ор нэр төдий хийсэн зураг төсөл олон тоогоор хийгдэж байгааг салбарын эрдэмтэд баримт дурьдан шүүмжилсээр байна. Үүний улмаас зургийн компаний нэр хүнд унаж байгаа төдийгүй услалтын системийн ач холбогдол нэр хүнд ч буурч байна.

Дэлхийн уур амьсгалын хуурайшлын хурдац болон урсгал усны багасалтыг анхааран үзэж услалтын системийн төслийн иж бүрдэлд усыг хуримтлуулах усан сан, цөөрмийн төсөл аль болох тусгахыг хичээж ажиллах хэрэгцээ тулгарч байна. Мөн усалгаатай талбайд өртөг өндөртэй бүтээгдэхүүн болох ургамлын үр үржүүлэх, техникийн таримал тариалах, жимс, жимсгэний аж ахуй эрхлэх нь илүү үр ашигтай байдгийг ч бодолцох шаардлагатай юм.

Бүх талбайгаа усжуулна эсвэл хуучин тоног төхөөрөмжийг ашиглана гэх мэтийн хэтэрхий өрөөсгөл хандлагаас татгалзаж байгаль дэлхийн хуурайшлын явц, ус, хөрсний нөөцийг тариалан эрхлэж байгаа аргатайгаа уялдуулан өөрийн аж ахуйн онцлогт тохирсон зураг төсөл зохиолгож ажиллах шаардлагатай болж байна. Өөрөөр хэлбэл талбайн багаахан хэсгийг услах, борооны усыг хуримтлуулан цөөн удаа ч болов услагаа хийх мэтээр нөөц бололцоондоо түшиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх хэрэгтэй гэсэн үг.

Сүүлийн жилүүдэд төсвийн болон олон улсын зээл тусламжийн хөрөнгөөр барьж байгуулсан томоохон услалтын системүүдийг бүрэн хүчин чадлын нь хэмжээнд хүрч ашиглаж чадахгүй байгаа тохиолдол олон байгаа тухай дээр дурьдсан. Зарим байгууллагын хийсэн судалгаагаар бага талбайд зориулсан жижиг оврын услалтын системийн ашиглалт сайн, үр ашиг өндөр байгаа нь тогтоогджээ. Иймээс Монгол оронд гол мөрөн болон нуурын усны нөөцөөс экологид нөлөөлөхгүйгээр авч ашиглаж болох хязгаар буюу экологийн урсацийн зохистой хэмжээг эцэслэн тогтоогоогүй байгаа энэ цаг үед нүсэр том услалтын системд зарцуулж байгаа хөрөнгийг багасгаж, жижиг оврын услалтын системийг дэмжих чиглэлээр зарцуулж байгаа хөрөнгийг нэмэгдүүлэх нь илүү ач холбогдолтой юм.

Өрхийн болон фермерийн аж ахуйн усалгаатай тариаланг буй болгох нь зах зээлийн хөгжлийн чухал хүчин зүйл бөгөөд тэднийг усаар хангахад улс, олон нийтийн байгууллагын дэмжлэг зайлшгүй хэрэгтэй болдог. Өрхийн тариаланд уян хоолойн сүлжээгээр услах аргыг өргөн нэвтрүүлэх нь дусаах усалгааны тоноглолын хөрөнгө оруулалтаас олон дахин хямд төдийгүй тариачид сурахад хялбар, үр дүнг хүртэхэд дөхөмтэй байна. Өрхийн тариаланд ашиглахаар дамарт уян хоолойн бороожуулах төхөөрөмжийг олноор оруулж ирээд ашиглаж эхэлжээ. Зөвхөн 2007 онд 25 га-услас хүчин чадалтай 50, 1 га-гийн хүчин чадалтай 150 иж бүрдэлийг оруулж тариачдад дэмжлэг үзүүлсэн байна. Гэхдээ ямар эх үүсвэрээс яаж ашиглах талаар зааж өгсөн зураг схемийг заавал хийж өгөх хэрэгтэй.

Зах зээлийн тогтолцоонд шилжих эхэн үед НҮБ-ын Хүнс тэжээлийн байгууллагын хөрөнгө оруулалтын төв, дэлхийн банкны дэмжлэгтэйгээр манай орны усалгаатай газар тариалангийн байдалд дүн шинжилгээ хийж, усалгааны арга техник, хэрэгцээг харгалзан дүгнэлт гаргажээ. Тэд Монгол орны тариачдын усалгааны гол арга нь бороожуулах арга байна гэдгийг тодорхойлоод өрхийн ба фермерийн аж ахуйн усалгаанд ашиглаж болох хямд бороожуулах төхөөрөмжийг удаан хугацааны хөнгөлөлттэй зээлээр олгож туршилтын ажил хийсэн нь сайн үр дүнд хүрсэн байна.

ЗУРГАА. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮНГИЙН ХҮРСЭН ТҮВШИН

Хөтөлбөр хэрэгжүүлснээр хүрэх үр дүн	Хүрсэн түвшин
1. Хүн амын унд ахуйн хэрэгцээ хангагдаж, ялангуяа малчид, говь, хээрийн бүс нутгийн хүн амын амьдрах нөхцөл, соёлын түвшин дээшилнэ.	2020 он хүртэл 10000 худаг ашиглалтанд хүлээн авч хөдөөгийн 200 гаруй мянган иргэний усны хэрэгцээг хангана гэсэн ерөнхий төлөвлөлт бий. 1998 оноос өнөөг хүртэл хөдөөгийн хүн ам, мал сүргийг усаар хангах ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээ жилээс жилд нэмэгдсээр ирлээ. Өнгөрсөн хугацаанд ашиглалтанд хүлээж авсан 5130 худгийн зонхилох хэсэг нь говь, хээрийн бүс нутагт хуваарилагджээ. Энэ ажлын дүнд 100 гаруй мянган иргэдийн усны хэрэгцээ хангагдсан байна. Энэ нь хөдөөгийн хүн амын таатай нөхцөлд амьдрах нөхцөлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн болно. Ажлын гүйцэтгэл төлөвлөсөн түвшинг хангаж байна.
2. Бэлчээр усжуулалтын үр дүнд мал аж ахуйн болон усалгаатай газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдэж, хүн амын хүнсний хангамж сайжирна.	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлснээр бэлчээрийн ашиглалт жигд болж ус бараадсан малын нягтрал буурч байгаа. Мөн ашиглаж чадахгүй байсан нөөц бэлчээрийг эргэлтэнд оруулж байна. 2020 он гэхэд бэлчээрийн 65.0 %-ийг усжуулах зорилт тавьсан бөгөөд одоогоор бэлчээрийн талбайн 41.0 % нь усжуулагджээ. Эдгээр хүчин зүйл нь малын тоо 43.2 сая толгойд хүрч өсөн, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэхэд тодорхой хувь нэмэр оруулсан гэж үзэх үндэстэй. Газар тариалангийн үйлдвэрлэл, нэн ялангуяа хүнсний ногооны үйлдвэрлэлд усалгатай тариалан нэн чухал үүрэгтэй. 2007 онд усалгаатай талбайгаас үр тариа 10330.2 тн, төмс 77581.5 тн, хүнсний

	<p>ногоо 74777 тн, жимс, жимсгэнэ 185.0 тн хураан авлаа. Энэ нь улсын хэмжээгээр хураан авсан үр тарианы 9.1 %, төмсний 68.1 %, хүнсний ногооны 94.5 % болж байна.</p> <p>Малын тоо 1998 оныхоос 12.1 сая толгойгоор, усалгаатай тариалангийн нийт ургацын хэмжээ 2003 оныхоос үр тариа 1.7 дахин, төмс 1.3 дахин хүнсний ногоо 1.1 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p> <p>Эдгээр тоо баримтууд нь бэлчээр, тариалангийн усжуулалтын дүнд хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах нөхцөл эрс дээшилж байгааг нотлон харуулж байгаа хангалттай үзүүлэлт юм.</p>
3. Байгалийн усны нөөцийг зохистой ашиглах, чанарыг хамгаалах удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагаа сайжирна.	<p>Бэлчээрийн худгийн ундрагыг 0.6 л/с-ээс 2 л/с байхаар тогтоож өгсөн нь газрын гүний усны нөөцийг зохистой ашиглах нэг арга хэлбэр юм. Хур бороо, цасны усыг ашиглан хөв, цөөрөм, усан сан байгуулж түүнийг түшиглэн бэлчээр усжуулах, тариалан эрхлэх талаар хангалттай заалтууд тусгагдсан хэдий ч дорвитой ажил хийгдэхгүй байна. Жишээ нь: Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын эхний үе шат /2003-2008он/-д хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Сэлэнгэ, Хэрлэн голын ай савд олон жилийн тохируулгатай усан сан байгуулах, улмаар усалалтын систем байгуулахаар тусгасан байдаг. Өнөөгийн байдлаар голчлон гол, мөрний усыг ашиглан усалалтын систем барих аргыг сонгож байна. Энэ нь хуурайшилт эрчимтэй явагдаж гадрагын усны түвшин багасаж байгаа ийм цаг үед ихээхэн эрсдэл дагуулсан ажил юм. 2004 оны оны 7 сарын 1-ээс мөрдөж эхэлсэн Усны багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулахад оролцож саналаа оруулсан.</p>
4. Усны нөөц байгалийн аясаар нөхөн сэргэх нөхцөлийг дэмжих, хомсдох, бохирдохоос хамгаалах арга ажиллагаа сайжирч, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын өнөөгийн түвшин дээшилнэ.	
5. Ус сувгийн зориулалттай барилга байгууламжид шинэ техник, технологи нэвтэрч тэдгээрийн ашиглалтын түвшин нэмэгдэнэ.	<p>2002 оноос хэрэгжиж эхэлсэн “Хөдөө аж ахуйн салбарын хөгжил” төслийн хүрээнд УВ, ХО, ГО, ЗА аймгийн 400 худагт Дани улсын GRUNFOS фирмийн тоног төхөөрөмж суурилуулсныг эс тооцвол ХХАА-н салбарын хувьд практикт нэвтрүүлчихсэн зүйл байхгүй байна. Харин судалж байгаа, туршигдаж байгаа зүйл бий. Жишээ нь, энэ онд АХБ-ны төслийн хүрээнд “CLEAN CAPE” төхөөрөмжийг оруулж ирэн 6 аймгийн 28 худагт суурилуулан туршиж эхлээд байна. Энэ төхөөрөмж нь худгийн цооног доторх усыг улирлын хөлдөлтөөс хамгаалсан, ариун цэврийн шаардлага бүрэн хангасан, хөрсний бохирдлоос хамгаалсан, цооногийн амсар хэсэг сайтар хамгаалагдсан, цооног доторх эд анги, ус шахуурга зэргийг солиход хялбар болсон, олон цооногт суурилуулж усны түвшин, усны чанар, бусад олон үзүүлэлтийг алсын удирдлагаар хянах боломжтой зэрэг давуу талуудтай юм. Одоо туршиж байгаа ажлыг хөтөлбөр хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд практикт нэвтрүүлж амжих боломж байна.</p>
6. Усны салбарын байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо, үйл ажиллагааны зохицуулалт сайжрах, усыг зохистой ашиглах, хамгаалах нэгдсэн бодлого хэрэгжих, түүнд зарцуулах хөрөнгийг зохистой хуваарилах, ашиглах нөхцөл бүрдэнэ.	<p>Хуулийн дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны хэрэг эрхлэх газар” байгуулагдсан нь усны салбарын байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулахад таатай боломжийг бүрдүүлж өгсөн.</p>

ДОЛОО. ҮНЭЛГЭЭ

№	Зорилт	Дүгнэлт	Үнэлгээ
---	--------	---------	---------

			ХУВЬ	ОНОО
1	Усны нөөцийн хэмжээ, чанарыг тогтоох эрэл хайгуул, судалгаа, шинжилгээний ажлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулах, ус хэрэглээний өсөн нэмэгдэх хэрэгцээг тасралтгүй бүрэн хангах	Энэ зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагааны чиглэлээс 4.1.2. болон 4.1.4. дэх заалт ХХААЯ-ны эрхлэх асуулатай холбоотой байна. Усаар дутмаг бүс нутагт усны нөөцийн хайгуул хийж хүн, малын усан хангамжийг нэмэгдүүлэх талаар томоохон ажлуудыг хийжээ. Тухайлбал, 2007 он дуусталх хугацаанд нийт 5130 худгийг хүлээн авч ашиглалтанд оруулсан байна. Тэдгээр худгуудын солбицолыг авсан хэдий ч нэгтгэн боловсруулалт хийж мэдээллийн бааз үүсгэх талаар хангалтгүй ажиллажээ. Иймээс хөтөлбөрийн 4.1.4.-т заасан усны нөөц, чанартай холбоотой мэдээлийг бүртгэн нэгдсэн мэдээллийн бааз үүсгэх үйл ажиллагаа хэрэгжээгүй гэж дүгнэж байна. Усанд чанарын шинжилгээ хийх зориулалттай зөөврийн лабораториор үе шаттай хангана гэсэн 4.2.10 дахь заалт хэрэгжээгүй байна.	90.0	4.5
2	Ус ашиглалтын уламжлалт арга, дэвшилтэт технологи, шинэлэг санаачилгыг нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагатай холбон судалж туршин нэвтрүүлэх	2002 оноос хэрэгжиж эхэлсэн “Хөдөө аж ахуйн салбарын хөгжил” төслийн хүрээнд УВ, ХО, ГО, ЗА аймгийн 400 худагт Дани улсын GRUNFOS фирмийн тоног төхөөрөмж суурилуулснаар хөтөлбөрийн 4.2.4 дэх заалт хэрэгжиж эхэлсэн бөгөөд уг төсөлд хамрагдсан малчид орчин үеийн баталгаатай техник ашиглах дадлага, туршлага хуримтлуулсан. ХХАА-н сайдын 2005 оны 106 дугаар тушаалаар “Гар худаг” уралдаан зарлаж болзол хангасан 4 сум, 12 баг, 20 иргэнийг шалгаруулж 13.9 сая төгрөгийн шагнал олгосон. Энэ нь ус ашиглалтын уламжлалт аргыг сэргээхэд чухал хувь нэмрээ оруулсан бөгөөд уралдааны дүнд 260 гар худгийг барьж байгуулан 301000 малыг усаар хангаж, 256000 га талбайг усжуулах бололцоог бүрдүүлсэн байна. Энэ онд АХБ-ны төслийн хүрээнд “CLEAN CAPE” төхөөрөмжийг оруулж ирэн 6 аймгийн 28 худагт суурилуулан туршиж эхлээд байна. Тариалангийн усжуулалтын хүрээнд зохион байгуулсан тодорхой ажил байхгүй байна.	85.0	4.25
3	Ус ашиглалтын болон байгалийн бусад сөрөг нөлөөллөөс усны нөөц хомсдож, бохирдохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, байгалийн аясаар нөхөн сэргээгдэх чадавхийг дэмжих үйл ажиллагааг усны нөөц, чанарын мэдээллийг үндэслэн хэрэгжүүлэх замаар байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалах	Худаг шинээр гаргах, сэргээн засварлах ажлын хэмжээ сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн нь бэлчээрийн ачааллыг жигдрүүлж, хөрсний эвдрэл, бэлчээрийн талхлагдалаас сэргийлэх нөхцлийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Бэлчээрийн худгийн ундрагыг 0.6 л/с-ээс 2 л/с байхаар тогтоож өгсөн нь байгалийн усны нөхөн сэргээгдэх чадавхийг дэмжих бололцоог хангаж өгч байна. Гадрагын ил усаар тэжээгдэхээр тооцоолсон услатын сисетүүдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нарийн хийгдэхгүй байна. Үүнтэй холбоотойгоор ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулсан зарим усалтын систем ашиглагдаж чадахгүй байдалд хүрч байна. Бэлчээр усжуулалтын зориулалттай төрөл бүрийн хийцийн худаг, уст цэг, усалтын системийн бариалга байгууламжийг эзэмшүүлэх болон хувьчлах замаар тэдгээрийн ашиглалтын түвшинг сайжруулна гэсэн 4.2.11 дэх заалт сайн хэрэгжиж байна.	75.0	3.75

		Хөтөлбөрийн 4.3.8.-д тусган оруулсан заасан Бороо, цас, үерийн ус зэрэг түр урсацыг хуримтлуулж тогтоох замаар байгалийн усны нөхөн сэргэх чадавхийг нэмэгдүүлж орчны бичил уур амьсгалыг сэргээх, томоохон гол, мөрөнд урсацын тохирууга хийх зэрэг асуудалын хэрэгжилт муу байна.		
4	Үерийн аюул, гамшиг болон гол мөрөн, булаг шандны ус татарч, улмаар хатаж ширгэх, усны эх үүсвэр бохирдох зэрэг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, учирсан хөнөөлийг арилгах, замаар иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх	Энэ зорилт ХХАА-н салбарт хамаардаггүй	--	--
5	Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагааг оновчтой, тасралтгүй, үр ашигтай зохион байгуулах эдийн засаг, эрх зүйн тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх	Улсын Их Хурлын 2003 оны 29 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын баримт бичигт хөдөө аж ахуйн усан хангамжийн талаар баримтлах бодлогыг 6 заалтаар томъёолон оруулсан байгаа. Засгийн газрын 2004 оны 57 дугаар тогтоолоор "Усны шинэтгэл-XXI" үйл ажиллагааны чиглэлийг батлаж усны нөөц, түүний зохистой ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, усны нөөцийн хайгуул, судалгааны ажил, усны сав газрын менежментийн шинэ тогтолцоог бий болгон хөгжүүлэх асуудлуудын талаар МУЗГ-аас ойрын 20 жилд баримтлах чиглэлийг тодорхойлсон. ХХАА-ийн, БО-ны, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-ыг гаргасан нь усны нөөц хомсдох, бохирдохоос хамгаалах, буруу ашиглахаас сэргийлэх, хяналт тавих шинэ тогтолцоог бий болгосон юм. Шинээр барьсан болон сэргээн засварлан услалтын системийг зохистой ашиглах, түүнийг тэжээгч эх үүсвэрийг хамгаалах талаар эрх зүйн нарийн зохицуулалт шаардлагатай байгаа. Хөтөлбөрийн 4.7.1-3.-г заасан мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх асуудалд ХАА-н усжуулагчдын оролцоо хангалтгүй байна.	75.0	3.75
Дундаж үзүүлэлт			81.25	4.06

Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн 2007 оны гүйцэтгэлийн түвшин 81.25 % буюу 4.06 баллаар **"Хангалттай"** үнэлгээтэй байна.

НАЙМ. ДҮГНЭЛТ

1. ХАА-н усжуулагчдын улсын зөвлөгөөнийг 2007 оны 3 дугаар сарын 21-нд зохион байгуулсан нь тус салбарын мэргэжилтнүүд ажлын ололт амжилтаа дүгнэж цэгнэх, тулгарч буй бэрхшээлтэй асуудлуудаа тодорхойлох, цаашид баримтлах хөгжлийн чиг хандлагаа тодорхойлох боломж олгосон чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон байна.

2. Бэлчээрт худаг шинээр барьж байгуулах, сэргээн засварлах ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах эрхийг аймгуудад бүрэн шилжүүлсэн нь гүйцэтгэгч, захиалагч, хэрэглэгчдийн хоорондын идэвхтэй харилцааг дэмжих чухал хүчин зүйл болжээ. Мөн бэлчээр усжуулалтын ажлыг орон нутагт зохион байгуулахад мөрдөх журмыг 2005 онд гаргаж хэрэгжүүлж эхэлсний зэрэгцээ тухайн жилд анхаарах асуудлуудын талаар жил бүр заавалчилгаа өгч ажилладаг байна. Үүний үр дүнд энэ чиглэлийн ажил, үйлчилгээ харьцангуй тогтворжиж хангалттай үр дүнд хүрсэн гэж дүгнэж болохоор байна.
3. 1998 онд усны өрөмдлөг, хайгуул судалгааны 30 гаруй байгууллага байсан бол 2006 оны байдлаар усны өрөмдлөг, хайгуул судалгааны 75, зураг төслийн үйл ажиллагаа эрхэлдэг 10 гаруй аж ахуйн нэгж, байгууллагатай болж, ажил гүйцэтгэх хүчин чадал 2000 онд 500,0 сая төгрөг байсан бол 2006 онд 4,0 тэрбум төгрөг, 2007 онд 10,0 тэрбум төгрөг болж өссөн байна. Эдгээр тоон үзүүлэлт нь хөдөө аж ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд тус салбарт мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч хувийн аж ахуйн нэгжүүдийн ажил гүйцэтгэх чадавх харьцангуй дээшилж хүний нөөцийн хувьд ч, техник хангамжийн хувьд ч бэхжсэн болохыг харуулж байна. Одоогоор өрөмдлөгийн болон барилга, угсралтын хэд хэдэн багтай болчихсон аж ахуйн нэгжүүд ч байна, өөрийн дотоод нөөц дээрээ тулгуурлан техникийн шинэчлэл хийж шинэ технологи нэтрүүлж байгаа аж ахуйн нэгжүүд ч байна, өөрийн зардлаар мэргэжилтнээ сургаж хүний нөөцөө бэхжүүлэх чадавхтай болсон нэгж ч байна.
4. Төрөөс их хэмжээний хөрөнгө зарцуулан барьж байгуулаад ашиглалтад хүлээлгэн өгсөн худаг, уст цэг, усны барилга байгууламжийн засвар үйлчилгээг цаашид ашиглагч, эзэмшигч нь өөрсдөө хариуцаж явах ёстой. Энэ тухай хөтөлбөр болон журамд тодорхой тусгаж өгсөн байгаа. Гэтэл аймаг, сумдын засаг дарга нар орон нутагтаа зохион байгуулах ажлыг хангалтгүй биелүүлж байгаагаас оролцооны хөрөнгөө бүрдүүлж өгч чадахгүй он дамжих, малчдын хооронд эзэмшлийн маргаан үүсэх, ашиглалт, хамгаалалтын муугаас эвдэрч тоногдох зэрэг сөрөг үзэгдлүүд тасрахгүй байсаар байна.
5. Дэлхийн уур амьсгалын дулаарал, монгол орны жил дараалсан ган болон хуурайшилттай уялдан гадрагын усны нөөц багасаж гүний усны түвшин ч өөрчлөгдсөөр байна. Гэтэл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэхдээ эрдэм шинжилгээний байгууллагыг татан оролцуулж байгаа хамтын ажиллагаа огт байхгүй байна. Энэ нь гүний худаг гаргах, томоохон услалтын систем барих зэрэг хөрөнгө зардал ихтэй ажилд ихээхэн эрсдэл үүсгэх нөхцөл байдлыг үүсгээд байна.
6. Сүүлийн жилүүдэд төсвийн болон олон улсын зээл тусламжийн хөрөнгөөр барьж байгуулсан томоохон услалтын системүүдийг бүрэн хүчин чадлын нь хэмжээнд хүрч ашиглаж чадахгүй байгаа тохиодол олон байна. Зарим байгууллагын хийсэн судалгаагаар бага талбайд зориулсан жижиг оврын услалтын системийн ашиглалт сайн, үр ашиг өндөр байгаа нь тогтоогдсон байна. Иймээс Монгол оронд гол мөрөн болон нуурын усны нөөцөөс экологид нөлөөлөхгүйгээр авч ашиглаж болох хязгаар буюу экологийн урсацийн зохистой хэмжээг эцэслэн тогтоогоогүй байгаа энэ цаг үед нүсэр том услалтын системд зарцуулж байгаа хөрөнгийг багасгаж, жижиг оврын услалтын системийг дэмжих чиглэлээр зарцуулж байгаа хөрөнгийг нэмэгдүүлэх нь илүү ач холбогдолтой юм.
7. Усалгаатай тариаланг хөгжүүлэх ажлын хүрээнд цас, бороо, үерийн усыг хуримтлуулан усан сан байгуулж ашиглах асуудал тусгагдсан. Гэсэн хэдий ч боломж нь өдрөөс өдөрт хумигдсаар байгаа гадрагын ил усны нөөцөөс шууд тэжээгдэх услалтын систем зонхилсон хэвээр байна. Тиймээс услалтын систем байгуулах талбайн сонголт, хөрсний чанар, ус цуглуулах талбайн хэмжээ, усны

ууршилт, газрын доорхи усны шингэлт, гадаргын урсац, зам тээвэр, эрчим хүчний хангамж, ашиглалтын үр ашиг зэрэг иж бүрэн судалгаа хангалтгүй хийгдэж байгаад зураг төслийн байгууллагууд онцгой анхаарах хэрэгтэй байна.

ЕС. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- ✓ Аймгийн төвд байгаа лабораторид усны дээж хүргэх асуудал ихээхэн бэрхшээлтэй байгаатай холбоотойгоор алслагдсан бүс нутгуудад барьж байгуулж буй худгийн усны чанарын шинжилгээ бүрэн хийгдэж чадахгүй байна. Иймээс усны чанарыг тодорхойлох зөөврийн багаж, төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжийн талаар судалгаа хийж нэн даруй туршиж эхлэх хэрэгтэй байна. Мөн нар, салхины эрчим хүчийг ашиглах замаар ус өргөх төхөөрөмжийг ажиллуулахад чиглэгдсэн туршилт судалгааны ажлыг эхлүүлэх хэрэгтэй.
- ✓ Мал услах онгоц, талбайн болон дулаалгын овоолгын хавтан, бусад угсармал төмөр бетон хийцүүдийг ашиглалтгүй болсон хуучин худгуудаас зөөж хэрэглэх нөөц нэгэнт дууссан тул гүйцэтгэгч аж ахуйн нэгж бүр өөр өөрийн нөөц бололцоон дээр тулгуурлан янз бүрийн материалаар орлуулах, газар дээр нь цутгах аргыг хэрэглэж байна. Тэд үйлдвэрлэх түүхий эдээ тохируулан сонгох туршлага багатай байгаагаас гадна уурын хатаалгатай өндөр технологээр үйлдвэрлэх боломжгүй байгаа тул чанарын хувьд төдийлөн бат бөх байж чадахгүй байна. Худгийн барилгын хувьд ч бэрхшээлтэй асуудлууд олон бий. Дээрх бодит нөхцөл байдлыг харгалзан үйлдвэрийн аргаар онгоц, хавтан бэлтгэж нийлүүлэх, худгийн хэд хэдэн загварын барилга үйлдвэрлэх аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж үйл ажиллагааг нь эхлүүлэх шаардлагатай байна.
- ✓ Төрөөс ХХАА-н талаар ойрын үед баримтлах чиглэлд тусгагдсан "Ус өргөх тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслэл нийлүүлэх, засварын үйлчилгээ хүргэх бага оврын цех, туршилт судалгааны төв байгуулах" заалтыг хэрэгжүүлэх оновчтой хувилбарыг боловсруулан хэрэгжүүлж эхлэх шаардлагатай байна.
- ✓ Услалтын систем шинээр барих, сэргээн засварлах ажил хугацаандаа дуусахгүй байгаа, гүйцэтгэсэн ажил чанарын шаардлага хангахгүй байгаа, ашиглалтанд хүлээж авсан услалтын систем ашиглагдахгүй байгаа зэрэг нэн даруй засаж залруулах шаардлагатай байгаа дутагдууд олон байна. Ажил чанаргүй гүйцэтгэсэн, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдол услалтын систем барих ажлаас гадна бэлчээрийн худаг барьж байгуулах ажлын хүрээнд ч тохиолдсон. Гэтэл тэндэнд хариуцлага хүлээлгэсэн, хохирол барагдуулсан тохиолдол нэг ч байхгүй байна. Иймээс тусгай журам гаргаж, услатын системийн гүйцэтгэл, эзэмшилт, ашиглалтын үеийн харилцааг тодорхой болгон захиалагч, гүйцэтгэгчийн хэн буруутай нь хариуцлага хүлээж, үүссэн хохиролыг барагдуулдаг механизмийг хэрэгжүүлж эхлэхгүй бол их хэмжээний хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах дутагдал цаашид ч үргэлжлэх төлөвтэй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэсэн:

МХШҮГ-ын мэргэжилтэн

С.Дивангар

Танилцаж зөвшөөрсөн:
МХШҮГ-ын дарга

Д.Бат-Эрдэнэ